

## МОНГОЛ УЛСЫН БАРУУН БҮСИЙН ХӨГЖЛИЙН ГАДААД ХҮЧИН ЗҮЙЛ

*Л.Бэгзжав\**  
*М.Энхтуяа\*\**

БНХАУ-ын Баруун бүсийг хөгжүүлэх бодлого, Казахстан, ОХУ-ын хил орчмын хамтын ажиллагаа, Төв Ази дахь эдийн засгийн интеграци нь Монгол Улсад хэрхэн нөлөө үзүүлэх талаар энд авч үзэв.

### **1. Регионалистикийн шинжлэх ухааны тухай ойлголт**

Даяаршилтай зэрэгцэн бүсчлэл /регионалчлал/ явагддаг. Бүсчлэлийн талаар судлаачдын санал зөрж, зарим нь даяаршилын үр дүнд бий болсон үйл явц гэж үздэг бол нөгөө хэсэг нь түүний эсрэг авч үздэг. Бүсчлэлийг олон аргаар судалдаг юм. Регионалистик нь нутаг дэвсгэрийн нийгэмлэг болох үндэстэн дамнасан бүлэг, тухайн улсын болон бүсүүдийн даяаршилын эсрэг чиглэсэн гадаад, дотоод хүчин зүйлийг ашиглан өөрийн хөгжлийг бий болгох объектив үйл явцыг судалдаг. Регионалистик нь бүс нутгийн судалгааг хийхдээ, хэдэн төрлийн шинжлэх ухааны хандлагыг харгалзаж, регионалчлалын явцад өрнөж буй олон улсын харилцааны улс төр, эдийн засаг, соёлын өөрчлөлтийг объектив талаас судалдаг салбар хоорондын шинжлэх ухаан юм. Бүсчлэлийн үед төрийн функциуд нь олон улсын, үндэстэн дамнасан түвшинд шилждэг онцлогтой. Бүсүүд эрх ашгаа даяаршилын сөрөг өдөлтөөс хамгаалахын тулд олон улсын харилцааны бие даасан субъект болдог. Регионалистикийн онолын дагуу дотоодын бүсчилсэн бодлого нь тухайн улсын бүс нутгийн гадаад бодлогыг тодорхойлдог. Бүсийн хувьд бүс нутгийн байгууллагууд, орон судлал, улс орны дотоодын гэсэн таксономийн үндсэн 3 түвшин байдаг. Эдгээр нь дотроо бүсийн болон хил дамнасан түвшинтэй. Хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэхийн тулд бүсийн олон улсын хөдөлмөрийн хуваарь дахь оролцоо, хил орчим, хил дамнасан хамтын ажиллагааны янз бүрийн хэлбэрийг хэрхэн ашиглаж байгааг регионалистик судалдаг. Орон нутгийн нэгжүүд макро бүс, орон судлал, бүсийн түвшинд өөрийн соёл иргэншлийн кодтой бөгөөд хөгжлийн дотоод, гадаад хүчин зүйлийг зөв ашигласнаар амжилтанд хүрдэг. Үүний зэрэгцээ геополитик, геоэдийн засаг болон дотоодын хүчин зүйлийн нөлөөн дор үйлдвэрлэх хүчний бүс нутгийн зохион байгуулалтад өөрчлөлт ордог.<sup>1</sup>

Геоэдийн засаг буюу шинэ геополитик нь улсын хөгжлийн стратегийн тухай шинжлэх ухаан бөгөөд дэлхийд болон бүс нутагт эдийн засгийн аргаар ноёрхолоо тогтоох арга замыг судалдаг. Геоэдийн засаг

\* Л.Бэгзжав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), профессор

\*\* М.Энхтуяа - Үндэсний хөгжлийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

нь бүс нутгийн бүлэглэл, тухайн улс хоорондын эдийн засгийн харилцааг бүсийн түвшинд ч судалдаг. Үүнээс бүс нутгийн эдийн засаг хэмээх эдийн засгийн хавсарга шинжлэх ухаан хөгжиж, үйлдвэрлэлийн ашигтай байрлал, бүтээгдэхүүний борлуулалтын зах зээлийн баазыг судалдаг. Бүс нутгийн эдийн засаг нь АНУ-д 1950-иад оноос хойш хөгжиж эдийн засаг, эдийн засгийн газар зүйн зааг дээр үндэслэсэн.<sup>2</sup>

АНУ, Европын Холбоо, Япон, БНХАУ зэрэг орон бүсчилсэн хөгжлийн бодлого хэрэгжүүлэн хөгжлийн оргилд хүрсэн. АНУ-ын хөгжлийн нууц нь “хөгжлийн туйл” болох хөгжлийн тодорхой цэгүүд дээр тулгуурлан амжилтанд хүрснийг өнөөдөр Калифорни мужийн жишээн дээр харж болно. Тус мужийн ДНБ Германы ДНБ-тэй тэнцдэг. Мөн хөгжих ирээдүйгүй гэж тооцогдож байсан бүсүүддээ Америк нь нэн таатай эдийн засгийн нөхцөл бүрдүүлж, бизнесийн бүх талын хөнгөлөлт үзүүлэн, маш гайхалтай үлгэр жишээг дэлхий дахинаа үзүүлж чадсан. Ямар ч хөгжих нөөц, боломжгүй Силиконы хөндий нь өнөөдөр бүх дэлхийг Интернетийн сүлжээгээр удирдаж байна. Харин Европын Холбооны интеграцийн зорилго нь бүсүүдээс “еврорегион” бий болгон тэдгээрийн нөөц, потенциалыг нэгтгэн ашиглахад оршдог.<sup>3</sup> Японы хөгжлийн нууц нь “технополис” буюу “технопарк” дээр үндэслэн, дэлхийд электроник барааны үйлдвэрээр тэргүүлдэг.

## **2. БНХАУ-ын бүсчилсэн хөгжлийн бодлого буюу “хөгжлийн туйлын” зам**

Хятад улс “соёлын хувьсгалын” дараа гүн хямралд автаж, социалист чиг баримжаагаар улс орноо хөгжүүлсэн ч, хүн ам өлсгөлөн, туйлын ядуу хэвээр, нийтдээ социалист орнууд ядуурсаар байхад ганц ЗХУ нефть, хийн ашиг олж, Барууны орнууд улам хөгжиж байсан үе байв. БНХАУ-ын өмнө хөгжлийн шинэ стратегийг боловсруулах зорилго тавигдаж, дэлхийн орнуудын хөгжлийн загварыг БНХАУ-ын эрдэмтэд гүнзгий судалж, Дэн Сяопины шинэчлэлийн замаар улс орон өндөр хөгжилд хүрсэн нь өнөөдөр бэлхнээ харагдаж байна.

Өмнө нь Хятад улс зөвхөн социалист орнуудтай харьцдаг, Хятадын эрдэмтэд гадаадын эрдэмтдийн судалгааг судлахад ч хориотой үе байв. Олон улсын тавцан дээр Хятад хаалттай байсныг АНУ-ын эрдэмтэд тэмдэглэдэг. Хятадын эрдэмтэд олон улсын харилцааг харьцангуй саяхан судалж эхэлсэн. Дэн Сяопины шинэчлэлийн санааг Бээжингийн удирдлага бүрэн ойлгохгүй эргэлзэж, зах зээлийн чөлөөт өрсөлдөөнийг таашаахгүй, хуучинсаг үзэлтэй байсан учир тэрбээр өмнөд хотуудаар явж ухуулга хийжээ. Барууны нөлөөг түүхэндээ амссан өмнөд мужийн хүрээнийхэн Дэн Сяопины бодлогыг илүү ойлгож дэмжиж байв. “Хятадын онцлогтой социализм” хэмээх чиг баримжааг барьсан БНХАУ нь АНУ-ын туршлагыг сонгон зах зээлийн

системд шилжин, нутаг дэвсгэр дээрээ “донор-бүсүүдийг” бий болгож эхлэв.

Дэлхийн хөгжлийн хоёр хандлага болох даяаршил, бүсчлэлд үндэслэн Хятад улс хөгжлийн стратегиа маш сайн боловсруулсан. Социалист системээ хэвээр хадгалж эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлэх нь хүн ам ихтэй орны хувьд өөрчлөлт шинэчлэл хийхэд чухал байв. Энэ хандлагын аль аль нь хятад хүний хувьд ашигтай санагдаж, дэлхийн аж ахуйд аажмаар, өөрийн орны эдийн засагт хэрхэн хохиролгүйгээр нэвтрэхийг судалж, өнөөдөр ДХБ-ын хүрээнд ч тохируулсан.

БНХАУ эдийн засгийн хөгжлийн замаа “Хятадын онцлогтой социализм” гэж албан ёсоор нэрлэдэг ч, барууны эдийн засагчид санал үл нийлдэг. Учир нь Үндсэн хуулийн дагуу БНХАУ социалист улс боловч, ДНБ-ний 70% хувийн секторт оногдож, 2004 онд Үндсэн хуулинд орсон өөрчлөлтөөр хувийн өмч халдашгүй эрхтэй болсон. Мөн социализмын хөгжлийн туршлагын тухай судалгаанд БНХАУ-ын туршлага огт ороогүй байх жишээтэй.

Бүсчилсэн хөгжлийн онцлог нь АНУ, ЕХ, Япон зэрэг орны туршлагад тулгуурлан нутаг дэвсгэрийнхээ “хөгжлийн туйлуудыг” тодорхойлон, далайн эрэг дагуу эдийн засгийн чөлөөт бүс (ЭЗЧБ) байгуулсан явдал юм. Зөвхөн ЭЗЧБ биш, регионалистикийн онолын дагуу хил орчмын худалдаа, хотжилт, технопарк, өөрөөр хэлбэл эдийн засгийн хөгжлийн бүхий л хэлбэрийг хөгжүүлсэн. Манай эрдэмтдийн судалгаанд зөвхөн ЭЗЧБ-ийн тухай тэмдэглээд, хил орчмын бүсийн үүрэг ролийг тэмдэглэх нь цөөн, бараг байхгүй. Хятадын бүсчилсэн бодлогын гол зорилго нь өөрийн мужуудыг дэлхийн эдийн засагтай аажмаар холбоход оршиж байгаа юм.

Гадаадын шинжээчдийн үзснээр, бүсчилсэн хөгжлийн шинэ стратегийг боловсруулахдаа, эхний шатанд БНХАУ-тай хил залгаа орны бүсүүдийн эдийн засгийг өөрийн эдийн засагтай интеграцлах, холбох явдал байв. Өөрөөр хэлбэл, хил залгаа орнуудын эдийн засаг Хятадын хил орчмын мужуудыг хангах, хөгжилд нь үйлчлэх зорилготой байсан. БНХАУ 2010 он хүртэлх хөтөлбөр боловсруулан хилийн 6 том бүс байгуулж, нэг хилийн бүсэд хэдэн муж, зарим мужийг хувааж оруулсан. Оростой хил залгаа Харбин хот төвтэй зүүн-хойтын Хармөрөн, Зилинь муж, Ляонин мужийн хойд хэсэг, ӨМӨЗО-ы зүүн хэсэг орсон. Хил орчмын хамтын ажиллагаанд Оросын субъектүүдээс Приморье, Ар Байгалийн бүсүүд оролцдог. Хоёрдох төв нь ШУӨЗО-ы Урумчи хотод төвлөрч, бүтэцдээ Шэньси, Ганьсу, Хөхнуур мужууд, Нинся хотон, Шинжаан, ӨМӨЗО-ы баруун хэсгийг багтаасан. ТУХН-ийн талаас Казахстан, Кыргызстан, Узбекистан, Туркменистан ордог. Эдгээр нь нийлээд “Их Өрнөд” хэмээн бүс бий болгох учиртай.

Монгол Улсыг тойроод хоёр талаас нь Хятадын хилийн хоёр том бүс оршиж, Монголын эдийн засагтай яаж холбох гэж байгаа нь

тодорхой юм. Үүнд, Монголын баруун аймгуудыг Урумчи хотоос “удирдан”, харин зүүн-өмнөд талаас Эрээн хот, Хөх хот байж болох юм. Магадгүй, Монгол-Хятадын хил дээрх томоохон боомтууд ч ийм үүрэг гүйцэтгэж болох юм. Энэ талаар Монголын эрдэмтдийн судалгаа хараахан гараагүй байна.

1990 оноос хойш БНХАУ эрчимтэй хөгжсөний үндэс нь Оросын баялгийг хямд үнээр авч, Орос улсын төсөвт орох мөнгийг татаж байсан үе Орос Барууныг чиглэсэн бодлого барьж, Азийн бодлогоо идэвхигүй хаясан үетэй таарснаар Хятадад таатай нөхцөл бүрдүүлсэн гэж Оросын эрдэмтэд үздэг.

Бүсчилсэн бодлогын эхний ээлжийн зорилт нь “эдийн засгийг интернационалчилах онцгой бүсүүд”-ийг бий болгохдоо, “харилцан нөхсөн” зарчим дээр тулгуурласан. “Харилцан нөхөх” зарчим нь олон улсын хөдөлмөрийн хуваарийн онолын гол зарчмын нэг бөгөөд дэлхийн аж ахуйн бүтцийн харилцан хамаарал буюу нэг орны эдийн засгийн дотоод өөрчлөлт нөгөө орны эдийн засгийн бүтцэд нөлөө үзүүлдэг.

Регионалистикийн онолын дагуу дотоодын бүсчилсэн хөгжлийн бодлого тухайн улсын бүс нутгийн гадаад бодлогыг тодорхойлдог гэсэн гол зарчимтай. Мөн *хятад хуний* өвөрмөц сэтгэлгээ чухал үүрэг гүйцэтгэснийг Барууны шинжээчид тэмдэглэдэг. Дэлхийн *регионалистикийн* шинжлэх ухааныг Хятадын судлаачид гүнзгий судалж, регионалчлал нь зарим үед эдийн засгийн онолын хувьд интернационалжих хэлбэрийн зарчимд үндэслэн улс орныхоо хөгжлийн стратегийг боловсруулав. Барууны шинжээчдын үзснээр, дэлхийн эдийн засгийн онол, хуулиуд Хятадад бүрэн хэрэгжихгүй, “хятад онцлогтой” болон хувирч, хятадууд хууль бус зүйл үйлдэхдээ гарамгай гэсэн хандлагатай байдаг аж.<sup>4</sup>

### **3. Баруун бүсийн хөгжлийн стратеги**

БНХАУ нь өөрийгөө тойруулан, бүх чиглэлд бүс нутгийн бодлого явуулж эхэлсэн. Өнөөдөр Хятад Барууны хөгжлийн загвараар буюу “бүсүүдийн ялгааг арилгах” түвшинд хүрсэн. “Хөгжлийн туйл” буюу Эдийн засгийн онцгой бүс нээх нь дотоодын капиталаа шинэ газар төвлөрүүлэх, хөгжингүй газраас хөгжиж буй бүсэд шилжүүлэх явдал юм.

Баруун бүсийг хөгжүүлэх бодлого нь анх Төв Ази /ТА/-д Хятад үйлдвэрлэлийн бараа нийлүүлэхдээ “ганзагын наймаанаас” эхлэн, дамжин Оросын зах зээлд гаргаж, аажмаар бүсийн зах зээлийг эзэлсэн. Кыргызстан ДХБ-д элссэний дараа Хятадын хамтарсан үйлдвэрүүд нээгдэж, “Кыргызстанд үйлдвэрлэв” шошготойгоор Европын зах зээлд экспортлосон. Хятадын хөгжлийн донор-бүс Гуанжоу мужийн үүрэг роль өндөр билээ.

Ийм үзэгдэл Монголд ч ажиглагдсан. БНХАУ ДХБ-ийн гишүүн болоогүй үедээ хөрш орнуудын боломжийг ашиглан, “Монголд

үйлдвэрлэв” шошготойгоор АНУ, Канад руу бэлэн, хүүхдийн хувцас экспортлосон. Гуанжоу хот, юуны түрүүнд, БНХАУ-ын гадаад нүүр, царай, энд улирал тутам улсын үйлдвэрүүдийн дэлхийн түвшинд үзэсгэлэн явагдаж, барааны үнэ маш хямд. Үүний зэрэгцээ “гадаад оронд үйлдвэрлэсэн” шошготой бараа ихтэй, дэлхийг дууриамал бараагаар хангадаг нэртэй хот. Монголын том дэлгүүрүүд эндээс Барууны загварын бэлэн хувцас, тавилга, электрон бараа, “Герман гутал”, “Франц сүрчиг”, “Солонгос хувцас” г.м. бүхий л төрлийн “брэнд” барааг үнэтэй худалдаалж байгаа нь аль хэдийн нууц биш билээ. “Монголд үйлдвэрлэв” хаягтай бараа захиалгаар үйлдвэрлэж, реэскпортоор Баруунд гаргадаг тохиолдолд байдгийг ч тэмдэглэдэг.

Баруун бүсийн хоцронгүй байдал, өмнөд мужуудаас ялгаатай нь сүүлийн үед улам тодорч байгааг сүүлийн 5 жилийн ХКН-ын төлөвлөгөөнүүдэд анхааран, *дотоод, гадаад* арга хэмжээ авч, хил залгаа орнуудын нөөц потенциалыг татан оролцуулахыг зорьж байна. Гадаадын зах зээлийг “зөв ашиглах” нь дотоодын зах зээлийн өөрчлөлт шинэчлэлийн оновчтой арга зам гэж үздэг.

Баруун бүсийн стратегийг 3 чиглэлээр тодорхойлж болно: 1/ “гаднаас татаж, дорнод зүгт нэгдэж, баруун зүгт гарц бий болгох”, 2/ “Өрнөдийг чиглэсэн бодлого явуулах”, 3/ “гаднаас авч, дотооддоо нэгдэх”.<sup>5</sup>

Сүүлийн 15 гаруй жилд Урумчи хотын хөгжил Хятадын *бусчилсэн хөгжлийн* амжилтын тод жишээ юм. Одоо Урумчи нь Хятадын, ТА-ийн бүс нутгийн эдийн засаг, санхүү, улс төрийн томоохон төв. ШУӨЗО-ы эдийн засгийн үр ашигтай өөрчлөлт шинэчлэлийн суурь эрчим хүч, олборлох салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд оршиж, бүсийг хөгжүүлэх гарц юм. ШУӨЗО нь ТА-ийн орнуудтай өрсөлдөх хэмжээний бүс болж, регионалистикийн үүднээс АНУ-ын бүсүүдтэй тэнцэх бүс болон хувирч байгаа юм.

БНХАУ-ын Засгийн газар хил залгаа орнуудын нөөц чадавхид үндэслэхдээ, түлш-эрчим хүчний төслийн хэрэгжилт нь ШУӨЗО-ы аж ахуйн цогцолборыг хил залгаа орнуудтай холбосноор хангагдах ёстой байв. Байгаль орчин хамгааллын хүрээнд зарим төслийг зогсоосон. Хятад, Монгол, Казахстан, Оросын бүсүүдийн аж ахуйн цогцолборыг интернационалчилах буюу хооронд нь холбохдоо “харилцан нөхсөн” зарчимд тулгуурласан. Ийм аргаар Шинжааны хөгжлийг хангах ёстой. *Хятад, Казахстаны* “харилцан нөхсөн” зарчимд тулгуурласан эдийн засгийн интеграци хоёр орны эдийн засгийг хөгжүүлэх арга зам гэж үзсэн. Гэвч Хятадын хувьд энэ зарчим түүхий эдийн нөөц, зах зээлийг хоёуланг эзэмших утга санаа агуулдаг гэж Казахстан тайлбарладаг. Шинжаан уйгарын улс төрийн асуудалд хүний эрх хувь хүний эдийн засгийн эрхээр Хятад тайлбарлах болно гэж Казахстаны тал үздэг.

Иймээс 1990 оноос хойш БНХАУ ТА-ийн бүс нутаг, ШХАБ-т ямар бодлого явуулж ирснийг үечлэн үзэх нь зүйтэй.

#### **4. Төв Азийн бүс нутгийн интеграци дахь БНХАУ-ын хүчин зүйл**

Эдийн засгийн онцгой бүс, хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэр байгуулснаар хөрш орнуудтайгаа анхан шатны хамтын ажиллагааг Хятад эхлүүлсэн. Өнөөдөр улс төрийн хувьд, Хятад бүс нутгийн эдийн засгийн бодлогоо ШХАБ-ын хүрээнд санал болгож, хоёр талын харилцаанд ч тусгадаг. Байгуулагдсан цагаас хойш ШХАБ хүрээгээ тэлж, хамтын ажиллагааны өнгө аяс өөрчлөгдөж байгаад Казахстаны тал дургүйцдэг юм.<sup>6</sup>

1990 оноос Хятад улс ТА-ийн бүс нутгийн бодлогоо амжилттай явуулж эхний үед хилийг баталгаажуулах зорилгоор эдгээр оронтой гэрээ байгуулж, сүүлд ШХАБ болгон хувиргасан. ЗХУ-ын үед ТА-ийн орнуудыг хятад-оросын харилцааны хүрээнд авч үзэж байсан бол, 1990-ээд онд БНХАУ-ын гадаад бодлогод тодорхой байр суурь эзлэх болсон.<sup>7</sup>

Хятадын ТА дахь бодлого үндсэн 3 үе шаттай:

1. 1990-д онд ТА-ийн орнуудтай дипломат харилцаа тогтоож, хятад-зөвлөлтийн үеэс үлдсэн асуудлуудыг шийдвэрлэх эрх зүйн үндэс, итгэлцлийг бий болгох.

Хятадын эдийн засгийн харилцаа хязгаарлагдмал, тээврийн замаар холбогдсон Казахстан, Кыргызстантай худалдаа болон “ганзагын наймаа” хийж байсан. Нэг талаас, Хятад 1990-д онд амжилттай бодлого явуулсан гэж үздэг ч, нөгөө талаас, ТА-ийн орнуудтай эдийн засаг, институцын хамтын ажиллагаа хөгжүүлэхээ болгоомжилж байсан нь Оростой харилцаагаа сайжруулах шаардлагатай тулгарсан. Энэ бүс нутагт Хятад ганцаараа амжилтанд хүрэхгүйгээ ойлгож, Оросын потенциалыг ашиглах хэрэгтэй байв.

2. 1990-д оны дунд үе–2001 оны 9-р сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд тус бүс нутгийн институт, механизмыг бий болгож, Хятадын эдийн засгийн нөлөө хүчтэй болсон.

Хятадын бодлого бүс нутгийн асуудал руу нэвтэрч эхлэв. Үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолоос гадна, эдийн засгийн сонирхол өсч, хил орчмын худалдаа эрчимжсэн. Баруун бүсээ хөгжүүлэхийн тулд эдгээр орны зах зээлийг ашиглах, эзэмших шаардлагатай болов. 1990-д онд ТА, Каспийн тэнгисийн гүнд газрын тос, байгалийн хийн нөөц тогтоогдсон. БНХАУ-ын эрчим хүчний нөөцийн гадаад боломжийг нэмэгдүүлэх зорилгоор улсын гадаад бодлогод ТА-ийн бүс нутаг чухал байр суурь эзлэх болов.

3. “9-р сарын 11-ээс” хойш одоо хүртэл Хятадын бодлого эрчимжиж, бүс нутгийн байдлыг хянаж, Хятадын талд ашигтай бус байдал гаргахгүйн тулд тэмцэж эхэлсэн.

Өнөөдөр Төв Азид Орос, Хятадын “мөнхийн ашиг сонирхол” нийлдэг. БНХАУ-ын гадаад бодлогод ТА-ийн чиглэл анх бүс нутгийн ач холбогдолтой болж, өнөөдөр глобал түвшинд хүрчээ. ТА-ийн газрын тос, байгалийн хийн нөөцийг ашиглах, тээвэрлэх Хятадын ашиг сонирхол нь АНУ-ын бүс нутгийн бодлоготой мөргөлдөж эхлэв. АНУ тус бүс нутагт улс төр, эдийн засаг, цэргийн өөрчлөлт хийж эхэлсэн. Иймээс БНХАУ ШХАБ-ыг бэхжүүлэх, хоёр талын эдийн засгийн харилцааг хөгжүүлэх болсон. Мөн *регионалистикийн* үүднээс авч үзвэл, Хятадын дипломат бодлого гүнзгийрч, ТА-ийн орны *бусийн элит*-ыг дэмжиж, янз бүрийн эдийн засгийн төсөл боловсруулж эхлэв.

### **5. ШХАБ-ын стратегийн онцлог**

1990-д оны сүүлд Хятад улс ТА-ийн орны хувьд бүс нутгийн тогтвортой, баталгаатай түнш болсон. Эдгээр оронтой хилээ баталгаажуулах зорилгоор өмнө байгуулсан механизмд үндэслэн, 1996 онд Хятадын санаачлагаар “Шанхайн 5” байгуулагдсан. 2001 онд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага /ШХАБ/ байгуулагдсан. *ШХАБ нь Хятадын санаачлагаар байгуулсан анхны олон улсын байгууллага юм.* 1999 онд БНХАУ ТА-ийн орнуудтай цагдаа, хууль, эрх зүйн байгууллагын хүрээнд гэрээ, хэлэлцээр байгуулав. 1999, 2000 онд Узбекистаны Исламын хөдөлгөөний цэргүүд Узбекистан, Кыргызстанд дайрсаны дараа Хятадын тал цэргийн тусламж үзүүлдэг болсон.

БНХАУ-ын бүсчилсэн хөгжлийн бодлогын дагуу ТА-ийн томоохон зах зээл нь төв, баруун мужуудыг хөгжүүлэхэд ач холбогдолтой учир ШУӨЗО-д үйлдвэрлэл хөгжүүлэх зорилго тавьсан. ТА-ийн зах зээл дээр хятад барааны нийлүүлэлт нь Баруун бүсийн хөгжлийн стратегийн хүрээнд бүсийн эдийн засгийн өсөлтийн арга зам байсан.

Хятадын нөлөөг багасгаж болох бүхий л боломжоос урьдчилан сэргийлж, ШХАБ-ын орнуудын харилцааг сайжруулах, олон улсын түвшинд тус байгууллагын нэр хүндийг өргөх, эдийн засгийн харилцааг эрчимжүүлж эхлэв. Хятад, Оростой хамтран бүс нутгийн орнуудыг татан оруулахаар эрмэлзэж, 2004 онд Монгол Улс, 2005 онд Иран, Пакистан, Энэтхэг оролцов. 2005 оноос Ажил хэргийн зөвлөл, Банк хоорондын нэгдэл байгуулагдсан. Гол зорилго нь санхүү, бизнес, шинжлэх ухааны хүрээнийхний хүчийг нэгтгэж, цаашид урт хугацааны эдийн засгийн хөтөлбөр хэрэгжүүлэх явдал юм. Эдийн засгийн салбарт анхаарч, 2006 оноос Хятад улс Чөлөөт худалдааны бүс байгуулах, бүс нутгийн тээврийн дэд бүтцийг бий болгох талаар хөөцөлдөж эхэллээ.

АНУ-ын цэргийн ажиллагаа идэвхжсэн ч, Хятадын тал аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилгоор Бүс нутгийн терроризмтэй тэмцэх бүтцийн хүрээнд хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлсэн. Улс төрийн шалтгаанаар эдийн засгийн хамтын ажиллагаа өсч, 2001-2007 онд

БНХАУ, ТА-ийн орнуудын худалдааны эргэлт 11 дахин буюу 16 тэрбум ам.долларт хүрэв.<sup>8</sup> 2008 оны эхээр хөрөнгө оруулалтын хэмжээ 11 тэрбум ам.долларт хүрч, олгосон зээлийн хэмжээ 3 тэрбум ам.доллар болов. Хятадын удирдлаган дор олон улсын түвшинд олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэхийг эрмэлзэж байна.

БНХАУ-ын гадаад бодлогын үндэс нь Хятад улсын хөгжлийг хангахад чиглэсэн ашигтай, таатай гадаад нөхцөл, орчныг бүрдүүлж, ирээдүйд дэлхийн их гүрэн болох зорилго юм. ШХАБ-ын механизмыг ашиглан, БНХАУ зөвхөн ТА-ийн бүс нутагт биш, олон улсын харилцаанд шууд нөлөөлөх, шийдвэр гаргах боломжтой болсон. Нөгөө талаас, ШХАБ-ын хүрээн дэх эдийн засгийн харилцаа дэлхийн түвшинээс илт хоцорч, түүхий эдийн нөөцөнд тулгуурлаж буй нь ТА-ийн орны урт хугацааны ашиг сонирхолд төдийлөн нийцэхгүй байна. Бусад орнуудтай Хятад инноваци, технологи, үйлдвэрлэлийн салбарт хамтран ажиллаж, ТА-д түүхий эдийн чиглэлийг өөрчлөхгүй, улмаар бэхжүүлэх сонирхолтой байгааг тэд тэмдэглэдэг. Мөн Казахстаны Ерөнхийлөгчийн дэргэдэх Стратеги судлалын хүрээлэнгийн доктор К.Сыроежкины тэмдэглэснээр, ТА-ийн орнууд НАТО-гийн “Энх тайвны төлөө түншлэл” хөтөлбөр, Хамтын хүчээр аюулгүй байдлыг хангах тухай Хэлэлцээр /Организация стран Договора о коллективной безопасности, ОДКБ/, ШХАБ-д зэрэг оролцож, үүнийгээ “хүчний тэнцвэр”-ийг хадгалахын тулд гэж тайлбарладаг юм.

Орос тус бүс нутагт Хамтын хүчээр аюулгүй байдлыг хангах тухай Хэлэлцээр, Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага /ЕврАзЭС/ байгуулж, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхийг хүсдэг ч, Хятадын дэмжлэг авч чадахгүй байгаа. Бүс нутагт Казахстан хүчтэй гүрэн гарч, Оросын гол өрсөлдөгч болсон. Оросын эрчим хүчний бодлогоос хэт хараат байдлаас гарах зорилгоор Хятадын CNPC KazMunaiGaz-тай 1304,5 км-ын хийн хоолойн барилгын Хэлэлцээрийг 2008 оны 8-р сард байгуулав. Ингэснээр Орос өөрийн монополийн Хятад, Энэтхэгийн зах зээлийг Казахстанд алдаж эхэлээ. 2012 онд Азийн оронд 60 сая тн нефть экспортлох тухайгаа 2008 онд Орос мэдэгдэж, Дорнод Сибирь-Номхон далайн хий дамжуулах хоолойн барилгын өртөг өссөн ч, хугацаандаа дуусгахыг чармайж байна.

Эдийн засгийн салбар дахь Хятадын банк, санхүүгийн бодлого анхаарал татаж байна. АНУ-ын эдийн засаг Хятадаас их хамаарч, “харилцан нөхсөн” зарчимд тулгуурлаж, юаны бодлого түүний эдийн засагт хохиролтойг тэмдэглэсээр ирсэн. 2007 онд юаний 40%-ийн ревальваци хийхийг АНУ шаардаж эхлэхэд, Хятад хариуд нь ЕХ-той өрсөлддөг экспортын эмвэг асуудал болох нисэх онгоц өргөнөөр худалдан авсан. “Хятад улсад юаний инфляци болсон ч, нэг л түвшинд хүчээр барьж байгаа нь олон улсын эдийн засгийн хуулийг зөрчиж, чанар муутай барааныхаа өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, их хэмжээний доллар хураах



боломж нээсэн” гэж саяхан хямралын үеэр шүүмжилсэн. 1970-д оны сүүлээс 20 жилд Гонконг, Макаоод Хятадын бирж, санхүү, цахим худалдааны хоёр төв нээгдсэн. Шэнжень хотыг Гонконгийн, Жухай хотын аялал жуулчлал, өндөр технологийн бизнесын төвийг Макоогийн жишгээр барьсан. БНХАУ алт, валютын нөөцийнхөө 70%-ийг долларын активт шингээж, өнөөдөр АНУ-ын долларын ханшаас шууд хамаарч байна.

Хятадын Ардын банк Оросын Центробанктай 2002 оноос хил орчмын худалдаанд юанаар тооцоо хийж,<sup>9</sup> ам.долларын үеэс илүү ашигтай ажиллаж байна. Өнөөдөр Хармөрөн мужийн 10 банк, Оросын талаас 19 банк үндэсний валютын тооцоонд оролцдог.<sup>10</sup> Орос, Казахстан хоёр үндэсний валютынхаа хөрвөх чадварыг нэмэгдүүлэхийг хүсч, Орос “санхүүгийн бүс нутгийн олон төвүүд байх ёстой” хэмээн “рублийн бүс” байгуулахаар тэмүүлж байна. Юаний ханш өсөх тусам Монгол төгрөгийн инфляци гүнзгийрч, инфляцийн гадаад хүчин зүйлийн нэг болсоор байна. Монгол Улстай хөрш орнууд рубль, юаниар тооцоо хийх санал дэвшүүлж байсан бөгөөд юаний хадгаламж буюу юаний шилжүүлэг гэх мэт хувийн оролцоотой бизнес гараад ирсэнийг Монголын эрдэмтэд тэмдэглэдэг.<sup>11</sup>

Долларын ханш АНУ, БНХАУ-ын харилцаанаас хамаарах нь тодорхой болжээ. Энд нэмэхэд, геоэдийн засгийн бодлогын гол утга нь эдийн засгийн аргаар дэлхийд ноёрхолоо тогтоох явдал бөгөөд АНУ, БНХАУ хоёрын өрсөлдөөний илрэл юм.

Доктор Л.Нямцэрэнгийн тэмдэглэсэнээр, “бүс нутгийн интеграцчиллын гэрээний гишүүн болоход улс төрийн олон учир шалтгаан байдаг.<sup>12</sup> Юуны түрүүнд, дотор нь түгжигдэх асуудал улмаар тухайн орны дотоод бодлогод нөлөөлөхтэй холбоотой. Бүс нутгийн хэлэлцээр нь улс төрийн болон эдийн засгийн бодлогын шинэчлэлийн талаар “амлалт гаргуулах механизм”-ын үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ энэ нь бусад бүх гишүүн орнуудын ашиг сонирхол, гэрээнд татан оролцуулсан түвшингээс хамаарч, ...улс төрийн дотоод шахалт болон лобби ажиллагаа бүс нутгийн гэрээний ямар хэлбэрийг сонгоход мөн нөлөөлнө. Тийм учраас хоёр том гүрний хооронд хавчуулагдсан жижиг орны хувьд энэхүү “дотор нь түгжигдэх” асуудалд маш болгоомжтой хандан, ялангуяа хоёр том хөршийнхөө нөлөөнд түгжигдэх бус, харин дэлхийн томоохон бүлэглэлийн хүрээнд эдийн засгийн буюу улс төрийн амлалт авах замаар түүний дотор “түгжигдэх” нь манай орны үндэсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой байж болох юм” гэж тэрээр тэмдэглэсэн.

## **6. БНХАУ-ын Эдийн засгийн интеграцийн онцлог, хил орчмын хамтын ажиллагаа**

Хятадын цэрэг-улс төрийн нэр томъёонд сүүлийн үед “стратегийн хил”, “амьдралын орон зай” хэмээх үг хэллэг хэрэглэгдэж байна.

“Амьдралын орон зай” нь глобалчлалын үед аливаа орон өөрийн нөлөөний бүс буюу “амьдралын орон зай”-тай байх ёстой бөгөөд улс орны аюулгүй байдлыг хангах үүднээс үүнийг эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хөгжлийн төлөө ашиглах ёстой.

Нээлттэй байдлын стратеги Хятадын эдийн засгийг зөвхөн глобалчлах биш, регионалчлахад туслана. “Шинэчлэл”, “нээлттэй байдал” эдийн засгийн регионалчлалын үед бүсчилсэн бодлого явуулахад дөхөм болно. Бүсчлэл /регионалчлал/ нь дотоод, гадаад чиглэлтэй. Дотоод бүсчлэл нь Хятадын нутаг дэвсгэрийг 1958 онд анх 7 бүсэд, 1980-д онд 6 бүсэд хувааж, бүс болгон үйлдвэрлэлийн өөрийн чиглэлтэйгээр үндэсний нэгдсэн зах зээлтэй улс ардын аж ахуйн цогцолборт интеграцчлагдах зорилготой. Орос улс Хятадын бүсчилсэн хөгжлийг хамгийн оновчтой, нэгэнт бий болсон “харилцан нөхсөн” эдийн засгийг цаашид хөгжүүлэхээс өөр арга зам үгүй гэж үзсэн. Өнөөдөр ОХУ-д 7 тойрог бий. Бүсчлэлийн стратеги нь бүсийн чиглэлтэй, онолын зарчим нь “хил хязгааргүй эдийн засаг ба шинжлэх ухаан”, “эдийн засгийн харилцан нөхсөн байдал”. Гадаад бүсчлэлийн зорилго нь эдийн засгийн интернационалжисан шинэ бүсүүдийг бий болгох, Хятадын мужуудийг хил залгаа орны бүстэй холбоход оршино. Хятадын онцлогтой интеграцийн загвар нь олон түвшинт: ЭЗЧБ, “нээлттэй район”, “хөгжлийн интернационалжисан район” бөгөөд “гадаад эх сурвалжаар дотооддоо хөгжих” бодлого юм.

Дотоод нээлттэй байдал нь техник-эдийн засгийн нээлттэй байдал, гадаад нээлттэй байдал нь ТА-ийн орнуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, ГХО-ыг татах, техник, технологи нэвтрүүлэх, экспортын чиглэлтэй үйлдвэрийг хөгжүүлэх, бүс нутгийн, олон улсын хөдөлмөрийн хуваарьт оролцох явдал. Мөн хил орчмын, “гүүрний”, “хөндлөнгийн” г.м. нээлттэй байдлын хэлбэрүүд бий.

Баруун бүсийн экспортын чиглэлтэй загвар Хятад улсын хөгжлийн анхан шатны загвар гэж Барууны судлаачид үздэг. Интеграцийн стратеги нь 5 гол чиглэл бүхий, дэд бүтэц, эрчим хүчний хоёр салбар бүсийг дэлхийн зах зээлтэй холбох зорилготой. Үүнд ШУӨЗО хамгийн тохиромжтой. Энэ бүс Монгол, Орос, Казахстан, Кыргызстан, Тажикстан, Афганистан, Пакистан, Энэтхэг зэрэг 8 оронтой хиллэдэг. Узбекистан, Туркменстан, Иранд гарцтай, Дундад Ази, Баруун Ази, Өмнөд Ази, Ойрхи Дорнод руу хамгийн ойрхон замтай. Эдгээр нөхцөл хөрш орнуудтай харьцах стратегийг тодорхойлдог гэж Хятадын тал үздэг.

Хятадын худалдаа дэлхийн аль ч өнцөгт үйлдвэрлэлийн “хөдөлгүүр” болж, ТА-ийн интеграци Европт чиглэсэн тээврийн хонгилыг байгуулах ёстой. ШУӨЗО транзит барааны бааз болж, цаашид нэмэгдэх төлөвтэй. Хятад улс “Торгоны замын” төсөлдөө

хөрөнгө нэмж, Афганистаны өрийг тэглэж, хүүгүй зээл олгосон. Хятад АНУ-ын зах зээлийг эзлэх зорилгодоо хүрч, харин Европын зах зээлийг эзлэхийн тулд Төв Азийн интеграцийг удирдах зорилготой. АНУ, Европын зах зээлийг эзэлснээр дэлхийг эзэлсэнд тооцогдох аж. Глобал хямралын дараа Европ нэгдэж, НАТО-д Франц эргээд орсон. Даяаршилын эрин үе дуусахыг тэмдэглэж, бүсчлэлийн үе ирж буй Барууны шинжээчид бичиж эхэлжээ.

Монгол-Хятадын худалдааны туршлагаас авч үзье. 1990-2003 онд "...Монгол Улс, Хятадад мал аж ахуйн түүхий эд экспортолж, монгол наймаачид дотоод зах зээлийнхээ хэрэгцээг хангахын тулд өргөн хэрэгцээний маш хямд барааг импортолж байв. Практик амьдралд Монголд хөнгөн аж үйлдвэрийн нэгжүүд үйлдвэрлэлээ түүхий эдээр хангах боломжгүй болжээ. Монгол Улс ямааны ноолуурыг дотоодоо боловсруулбал зах зээлд илүү ашиг олох боломжтой... 1999 онд Улаанбаатарын зах дээр ямааны боловсруулаагүй нэг кг ноолуурын үнэ 246 юань байсан бол, Хятадын зах зээлд 600-700 юань байв". Монголоос ноолуур нийлүүлдэг Хятадын пүүсүүд ноолуур авахын тулд улсын банкнаасаа хангалттай зээлийг авах бололцоотойг Германы эрдэмтэн У.Баркманн гярхай ажигласан байна.<sup>13</sup>

Мөн тэнд: "БНХАУ-ын дарга Зян Зэмний гаргасан Монгол-Хятадын "харилцан нөхөх" зарчим нь хамтын ажиллагааны нэн шинэ алхам болжээ. "Харилцан нөхөх" гэсэн нь юу гэсэн үг вэ? нэгдүгээрт: Хоёр улсын хооронд стратегийн чиглэлтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх, хоёрдугаарт: Монгол Улс болон БНХАУ дахь эдийн засгийн харилцааны үндсэн ашиг сонирхлыг харгалзах болон зохицуулах. Энэ үүднээс үзвэл, "харилцан нөхөх" зарчим нь хоёр улсын хоорондын дэд бүтцийн хэлхээ холбоог хөгжүүлэн бэхжүүлэх, аюулгүй бодлогын зохистой хүрээ тогтоохыг шаардаж байна. Хамгийн сайн жишээ бол, Оросын Ковыхтинскээс Хятад руу хийн хоолой тавих төслийн тухай санал шүүмжлэл юм. Тус хийн хоолойн төслийн хэрэгжүүлэлтийн хамгийн бага өртөгтэй зам бол Монголын төмөр замын дагуу чиглэл юм. Гэтэл Хятад улс, одоо болтол тодорхой бус учир шалтгаанаар энэ боломжийг хэрэгжүүлэхээс түдгэлзэж байна" гэж тэрээр тэмдэглэсэн. Энд нэмэхэд, хийн хоолойг Монголоор дамжуулах төслийг Оросын тал анх тавихад, Хятадын тал татгалзаж байсан. Түүхээс харвал, 2002 оны 6-р сард Орос-Хятадын стратегийн гэрээ байгуулагдаж, нэг сарын дараа ШХАБ байгуулагдсан.

Баримт, анализаас үзэхэд, 1990 оноос хойш БНХАУ-ын ТА дахь бодлого Монголд яах аргагүй шууд тусаж байсныг харуулж байна. ЗХУ задарч, түүний нөлөө ТА-д алга болсноор 5 улс шинээр тусгаар тогтнож, ШУӨЗО-д шууд нөлөөлж эхэлсэн. 1990-1995 онд Хятадын бүрэн бүтэн байдалд бодитой аюул тулгарсан. Монголд өрнөсөн

ардчилал байнгын болгоомжлолд хүргэж, мал аж ахуй дээр үндэслэдэг манай орны эдийн засгийн хөгжлийг саармагжуулахын тулд тодорхой хэмжээний бодлого хоёр хөрш орон зэрэг явуулсан гэж болно. Манай малчид ядуурч, Хятадын зах зээлээс хараат болсон нь бүсчилсэн бодлогын “гадаадын эх сурвалжаар дотооддоо хөгжих” зарчмын дагуу Хятадын тал иргэддээ улсын банкнаас хангалттай зээлийг олгож байв. Мөн экологийн цэвэр бүтээгдэхүүнд тооцогддог Монгол үйлдвэрлэлийн махыг Орос, Хятад хоёр махны бүтээгдэхүүнээр маш ихээр гачигддаг ч, худалдаж авахгүй бодлого явуулдаг.<sup>14</sup>

Эдийн засгийн хамтын ажиллагааны хил орчмын бүс, техник-эдийн засгийн эзэмшлийн бүс, шинэ өндөр технологи эзэмшлийн бүс нь мөн л хөрш орнуудтайгаа интеграцчлах эхний үе шат бөгөөд интеграцийн олон түвшинт “сүлжээ”-ний бүтэц бий болгосон. Эдийн засгийн интеграцийн төслийг улсын, орон нутгийн түвшинд зэрэг боловсруулж, 1993 онд ШУӨЗО-ны Шинжлэх ухаан, техникийн хороо хамтарсан олборлолтын төсөл бэлтгэсэн. Хятад-Казахстаны “Инин-Жаркент” хилийн хэсэг, Хятадын “Боро тала”, Казахстанд “Найрамдал” гэсэн Чөлөөт бүс байгуулах зорилго байв. 1996 онд Хятад, Казахстан, Орос, Монголыг багтаан эдийн засгийн бүсийн төсөл боловсруулжээ.

1998 онд ОХУ-д суугаа БНХАУ-ын ЭСЯ-ны Шинжлэх ухаан, техникийн хэлтэс “Эдийн засгийн түргэвчилсэн хөгжлийн улс хоорондын бүс” төслийг Оросын талд дэвшүүлсэн. Үүнд ШУӨЗО, Оросын Алтайн хязгаар, БН Алтай улс, Казахстаны Дорнод Казахстаны муж, Монголын Баруун аймгуудыг багтаан, онцгой бүсийн механизмыг боловсруулах 4 талын комисс байгуулж, худалдаа хийх үйлдвэрүүдэд таатай орчин бүрдүүлэх, гаалийн татварыг бууруулах, хилийн боомтын ажиллагааг сайжруулах г.м. зүйлүүд орсон. Хятадын нутаг дэвсгэр дээрээс ШУӨЗО-ны шинэ, өндөр технологи эзэмших бүс буюу технопарк нь энэ интеграцийг чиглүүлэн удирдах үүрэгтэй байжээ.

Интеграцийн санааг Хятад 1998 онд анх дэвшүүлсэн “Большой Алтай” нэртэй 4 орны зааг дээр байгалын цогцолборын төслөөс авсан гэж Оросын тал үздэг. “Их Алтай”-г өөртөө тохируулан өөрчилж, 2000 оноос Алтайд хоёр талын хэлэлцээ эхлэн, аж ахуйн салбарт хамтран ажиллах саналыг Хятад тавьсан. Энэ төсөл тэр үед бүх талаараа Оросын ашиг сонирхолд нийцэж, тээврийн хонгил барихаар талууд тохиролцов. Оросын Алтай нь Хятадтай 55 км газраар хиллэдэг. “Их Алтай” нь Алтайн хязгаар, БН Алтай улс, ШУӨЗО-ны Алтайн тойрог, Казахстаны Дорнод Казахстаны муж, Монголын Баян-Өлгий, Ховд аймаг зэрэг бүсийг багтаадаг. 1998 онд “Тогтвортой хөгжлийн Алтайн тунхаглал” баталж, Алтайн конвенци батлахаар ч санал болгосон. 2000 онд ОХУ-ын Алтайн хязгаарт Алтай уулын чуулган дээр тус төсөл улс төр-үзэл

суртлын үзэл баримтлалын хэмжээнд батлагдав. Үүний зэрэгцээ богино хугацаанд интеграцид тэргүүлэхийн тулд хил орчмын дэд бүтцийг бий болгохоор Хятад улс хоёр талын хэлэлцээ хийж эхэлсэн.

Хятадын интеграци гадаад нээлттэй байдлын зарчмаар нэгэн зэрэг олон түвшинт хэдэн төсөл хэрэгждэг. Шинжааны хилийн урт нь 5600 км, нийт 33 хилийн хошуу, хот, үүнээс 14 хошуу, хот нь нээлттэй статустай. Инин (Кульжа), Бор (Бор-тал), Тачэны Эдийн засгийн хамтын ажиллагааны хил орчмын бүс болон хөгжлийн бүсүүд нээгдсэн. Хятадын практикаас үзэхэд, хилийн боомт нээх явдал нь эдийн засгийн интеграци, “нягтралыг” бий болгох анхны алхам болдог. Баруун бүсийн дотоод өөрчлөлт Казахстаны эдийн засагт нөлөөлнө гэж үздэг. БНХАУ тус бүсээр Оростой харилцаагаа дамжуулан холбож, Алтайгаар дамжин Европ руу гарц бэлтгэж байгаа юм.

Шинжаанд 1992-1994 онд байгуулагдсан Урумчийн өндөр технологи, үйлдвэрлэлийн нээлттэй район, Шихэцэ, Куйтуны техник-эдийн засгийн нээлттэй район, Кульжа, Болэ, Чугучакын хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагааны район ажилладаг. Эдгээр бүсийн онцлог нь ихэнх үйлдвэрүүд хил залгаа оронд экспорт хийж, хамтарсан үйлдвэрийн эзэд, ажилчид нь хань үндэстэнээс бүрддэг.

Хятадын тал Казахстанд “Урумчи-Актогай-Алматы” хэмээх “эдийн засгийн өсөлтийн гурвалжин” буюу “хөгжлийн гурвалжин” нээх санал тавьж байгаа ч хамтын ажиллагааны хэлбэр нь тодорхой бүс байна. Мөн хилийн боомт нээх санал тавьсан. Хилийн хяналтгүй ганзагын наймаанаас болж, Хятадын боомтын тоог Орос цөөрүүлсэн. Хоргос хот төвтэй Инин-Жаркентын, Алашаньюкоу хот төвтэй Болэ-Дружбинская эдийн засгийн цогцолбор бүсийг тус тус байгуулах тухай ярьж байна.

ШУӨЗО нь Хятадын эдийн засагт түлш, түүхий эдийн нийлүүлэгч. Орос, ТА-ийн хувьд, нийтийн хэрэглээний барааны нийлүүлэгч. ЭЗЧБ буюу интеграцийн бүсийг зүүн-урд хил дээр ганц Хятадтай биш, Оросын Алтайн оролцоотой байгуулах нь илүү оновчтой хэлбэр гэж Казахстан үздэг. Үүнд:

1. ШУӨЗО-ы экспортын 80%-ийг Казахстан, Оросын хил залгаа бүсүүдэд нийлүүлдэг.
2. ШУӨЗО нь Казахстан, Оросын хил залгаа бүсэд үйлдвэрлэл, бүсчлэл бий болгоход нөлөөлөх гол хүчин зүйл.
3. Газар зүйн байршил.
4. Үйлдвэрлэлийн бүтцийн “харилцан нөхсөн” зарчмыг бий болгох явдал.

Нөгөө талаас, Казахстаны эдийн засгийн объектив байдал тус интеграцид бэлэн биш байгааг харуулж, зөвхөн зүүн-урд хил биш, Казахстан-Хятадын нийт хилийн дагуу интеграцид оролцох бэлтгэл хангалтгүй гэж үзэн хойшлуулсан. Мөн ШУӨЗО-ы эдийн засаг ч хүчтэй

болж чадаагүй, түүний бүтцэд эрчим хүч, олборлох салбар давамгайлдаг.

Эдийн засгийн онцгой бүс нээх нь дотоодын капиталыг шинэ газарт, өөрөөр хэлбэл донор-бүсээс хөгжиж буй бүсэд шилжүүлэх явдал учир “нээлттэй бодлогын” хүрээнд хань үндэстэнг Шинжаанд шилжүүлэн суурьшуулсан хуучин бодлогын давталт буюу хоёрдох үе шат гэж Казахстан үздэг. Өнөөдөр үйлдвэрийн тоо, капиталын хэмжээ улам нэмэгдсээр байна.

Казахстан, Оросын хувьд ЭЗЧБ нээх нь ГХО-ыг татах нөхцөл бий болгох учир ашигтай. Нөгөө талаас, эдийн засгийн байгууллагуудын хүрээнд Хятад цагаачдынхаа потенциалыг өргөнөөр ашигладаг. Казахстан, Хятад, Орос зэрэг 3 орны бүсийн макротүвшинд цагаачдын хүчин зүйл хүчтэй, ГХО орж ирэхэд хязгаарлагдмал байж магадгүй. Талдыкорганы мужид Жаркентын ЭЗЧБ нээж үзэхэд, хоёр талын хөгжил интеграцийн түвшинд хүрээгүйг харуулсан байна.<sup>15</sup>

2009 оны 12-р сарын сүүлчээр Алашанькоу хилийн боомтод Хятад-Казахстаны чөлөөт худалдааны бүс албан ёсоор ажиллаж эхэлснийг ШХАБ-ын вэб хуудаснаа тэмдэглэжээ. Иймд Казахстаны иргэд энэ хилийн бүсэд 1 өдрийн дотор визгүй нэвтэрч, өөрийн хэрэгцээний хятад бараа худалдан авах эрхтэй боллоо. Алашанькоу чөлөөт худалдааны бүсийн нээлтэнд Алматы мужийн Алакол аймгийн 150 төлөөлөгч оролцож, ШУӨЗӨ-ны Засгийн газрын орлогч дарга Ху Вэй энэ хилийн бүсийн нээлт цаашид Хятад, Казахстаны хил орчмын аймгуудын эдийн засгийн хөгжил, соёлын солилцоонд үүрэг гүйцэтгэнэ гэж тэмдэглэв. Түүнчлэн Алашанькоу нь Бортал-Монголын автономит тойрогт багтаж, 1990 онд улсын хилийн боомтын 1-р зэрэглэлийн статус авч, БНХАУ-ын баруун хилийн хуурай замын томоохон боомт гэж тооцогдсон. Иймээс урьдчилсан прогнозоор, 2010 онд боомтын ачааны эргэлтийн хэмжээ 26 сая тн-д хүрнэ.<sup>16</sup>

Гэвч Төв Азийн бүсийн интеграцид саад болж буй хүчин зүйл нь шашны тогтворгүй байдал юм. Ирээдүйд АСЕАН-ы хэлбэртэй ЭЗЧБ байгуулах илүү боломжтой, тус байгууллагын хүрээнд, юуны түрүүнд, аюулгүй байдал, энх тайвны асуудлыг хангаж, дараагийн шатанд хамтын ажиллагааны бусад салбарыг хамруулж, цаашид ШХАБ-ын хүрээнд аюулгүй байдлыг хангаж, Орос, Казахстаны хамтын санаачлага чухал гэж хоёр тал үзсэн. Казахстан, Орос хоёр бүс нутгийн интеграцийн байгууллагуудын аргачлал, хэлбэрийг шинээр авч үзэж, өөрийн ролийг 2006 оноос тодорхойлж эхэлсэн. ТА-д интеграцийн олон байгууллагууд байдаг ч, гол асуудал нь интеграцийн үүрэг ролийг зөв тодорхойлох юм. Интеграцийг Хятадтай холбохгүйгээр өөрийн байр сууринаас бодит байдал, прагматизмын үүднээс харж үзэх хэрэгтэй гэж хоёр тал үзсэн. Шинэ интеграцийн хэлбэр аль ч талд

ашигтай уян хатан, үндэсний асуудлаас хөндий зарчимд тулгуурласан тогтвортой байдлыг хангасан, төрөөр баталгаажуулсан шинэ байгууллага буюу нэгдэл, сүлжээний хэлбэртэй байх нь оновчтой.

Ирээдүйд ЭЗЧБ нээх боломж байгааг газар зүйн хөдөлмөрийн хуваарь нотолдог. Бүс нутгийн хөдөлмөрийн хуваарьт Казахстан, Орос түүхий эд, технологийн нийлүүлэгч болсон нь сөрөг тал ихтэй. Гэвч Шинжааны ЭЗЧБ-ийн эерэг туршлагыг судлах, өөрийн талд хэрэгжүүлэх арга замыг судлах, интеграцийн явцад оролцохын тулд хил залгаа бүсүүд хөрш орны хөгжлийн түвшинд хүрэх ёстой. Хятад, Казахстан, Орос орны эдийн засгууд бие биеэ “харилцан нөхөх” бүрэн боломжгүй, хөгжил нь жигд бус байна.

**Үүнээс дүгнэн үзэхэд,** Монголын Баруун бүсэд ЭЗЧБ нээх ховорхон нөхцөл бүрдсэн гэж үзэж болно.

“Алтанбулагт” ЭЗЧБ-ийн талаар олон жил яригдаж, ажил төдий урагшлахгүй нь Оросын байр суурьтай холбоотой бол, Баруун бүсийн ЭЗЧБ хөгжих хэтийн төлөвтэй. ЭЗЧБ нээх нь ГХО татах нөхцлийг бүрдүүлдэг. Казахстан, Хятад, Орос орны бүсийн макро түвшинд ГХО орж ирэхэд хязгаарлагдмал учир манай Баруун бүс Төв Азийн бүс нутагт, дээр тэмдэглэсэнээр, шинэ интеграцийн хэлбэрт тохирох, аль ч талд ашигтай уян хатан, үндэсний асуудлаас хөндий, тогтвортой байдлыг хангаж чадах, төрөөр баталгаажуулах боломжтой “нэгдэл, сүлжээний” хэлбэртэй бөгөөд улс төр, эдийн засаг, шашин, соёлын бүх талаас таатай нөхцөлтэй бүс юм. ТА-ийн орнууд Монголын нутаг дэвсгэр дээр Барууны орнуудтай уулзаж хамтран ажиллах боломжтой. Монгол Улс Баруун бүс нутгийн интеграцийг жинхэнэ утгаар бий болгох ирээдүйтэй. Төв Азид нөлөөтэй орнуудыг татан оролцуулах нь интеграцийн замаар Монголын байр суурийг бататган өгч, эрх ашгаа өндөр хэмжээнд хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах шинэ алхам болж өгнө.

Монголын “төвийг сахисан” байр суурь, бүх гишүүн-орны тэнцвэрийг хадгалах нь чухал. Монгол Улсын баруун хил дээр Барууныг түшиглэсэн ашиг сонирхолыг бий болгох нь Монголын гадаад бодлогод бүс нутгийн хүчин зүйл, нөхцлийг зөв ашиглах боломж олгох юм. Чингэхдээ стратегийн үүднээс түншээ сонгож, Барууны ашиг сонирхолын зэрэгцээ, Азийн орон Япон, Солонгосыг оролцуулж тэнцвэржүүлэх нь зүйн хэрэг. Мөн бүс нутгийн гол тоглогч Казахстанд эдийн засгийн ашиг сонирголоос гадна, бусад орны хүчин зүйлийг саармагжуулахад стратегийн өндөр ач холбогдолтой.

Хятад, Оростой хил холбосон энэ бүсэд, юуны түрүүнд, ОХУ-ын хил орчимд Аялал жуулчлал ба нөхөн сэргээх эдийн засгийн онцгой хоёр бүс Алтайд нээгдэж буйг анхаарч, хэрэгцээний хувьд ойролцоо, олон зүйлээр гачигдаж байгаа Тува, хоёр Алтай /БНУ, хязгаар/, Баруун Сибирь, мөн Казахстан, Шинжааны хүн амын хэрэгцээг

Барууны орнуудтай хамтарсан үйлдвэрийн бараагаар хангах зорилго дэвшүүлж болно. Казахстантай хамтрах ЭЗЧБ-ийн төсөлд Туваг оруулаагүйг анхаарч, Баруун Сибирийн үүрэг роль нэмэгдэх төлөвтэйг харгалзах ёстой. Төв Азийн хоцронгуй бүсэд Барууны технологийг сурталчлан Монголын экологийн цэвэр бүтээгдэхүүнд зүй ёсоор тооцогдог чанартай “Монгол брэнд”-ийг олон улсын түвшинд гаргах явдал юм. Эдгээр орны хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцдэг манай орны үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүн, мал аж ахуйн онцлогтой эдийн засгийн чухал салбар болох хүнсний үйлдвэрлэлийг өргөтгөх, бүхий л салбарт ГХО татаж, шинээр хамтарсан үйлдвэр нээх, хөрш орнуудын зах зээлд нэвтрэх боломж нэмэгдэнэ. Хөрш орнуудын хил орчмын худалдааны туршлагаас үнийн бодлогыг судлан зохицуулж, үнийг хямдаар тогтоож, хэрэглэгчдийг татан, Оросын талыг татгалзахгүйд хүргэж болно. Монгол үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүн Сибирийн ард иргэдийн таашаалыг хүртэж, тэд хэрэгцээндээ хэрэглэсээр ирсэн зэрэг туршлагатай уламжлалт хамтын ажиллагааг сэргээн баяжуулах хэлбэр болох юм.

Баруун бүсийн ЭЗЧБ байгуулах нь, юуны түрүүнд, Монголд тогтвортой хөгжлийн зам нээгдэж, Төв Ази, Өмнөд Ази, Зүүн хойд Азийг тэр чигт нь Европтой холбож, Монгол Улсын Евразийн бүс нутгийн интеграцийн төвийн үүрэг роль өсөх ирээдүйтэй. Үүний зэрэгцээ Төв Азийн орнуудын хамтын ажиллагааны CAREC байгууллагын хүрээнд интеграцийн үйл явцтай холбож болно.

БНХАУ-ын ЭЗЧБ, нээлтэй район, хот, сум зэрэг интеграцийн загварыг судлан, “Монгол онцлогтой” өөрийн бүс байгуулан, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн стратегитэй холбох, тээврийн асуудлыг шийдэхдээ, манай орны онцлогт тохируулан “олон талт загварын ЭЗЧБ” буюу агаарын загвартай нэгтгэж болох юм. УБ-Баруун бүс чиглэлийг өөр бүсийн “хөгжлийн тулгуур”-ын оролцоотойгоор хуваах буюу шинээр бий болгох, Баруун бүсийг Монголын дотоод интеграцитай уялдуулах нь стратегийн өндөр ач холбогдолтой. Ингэснээр хамтарсан үйлдвэрүүдийг бусад бүсэд байрлуулахад ашигтай болж, хөрөнгө оруулалтын хуулийн хүрээнд гадаад түншүүддээ хэрэгжүүлэх анхан шатны ажил болгож болох юм.

Регионалистикийн шинжлэх ухааны дагуу дотоодын бүсчилсэн хөгжлийн бодлого нь түүний гадаад бодлогын үндэс болдог зарчимд үндэслэн хэрэгжүүлэх Монгол Улсад таатай нөхцөл бүрдүүлж өгч байна. Доктор У.Баркманн “Шарын шашны хутагт хувилгаад тодруулах ёсон ба геополитикийн интервенц” хэмээх өгүүлэлдээ: “Бүс нутгийн харилцаанд Монгол Улс нь зөвхөн эх оронч үзэл эсвэл Монголоо гэсэн үзэл /mongolian self-identity/-тэй байж л улс төрийн хувьд сонирхолтой болох юм. Монголын үндэсний түүхийг мэдэх хүн бүхэн Монголын эх



оронч үзэл нь асар том түлхэх хүч болдогийг мэдэх билээ. Өнөөгийн нөхцөлд авч үзэхэд монголчууд эх оронч үзлийг бэхжүүлэх нь “Азидаа бүрэн эргэж ирж буй” хэрэг биш ... харин 3 талт харилцаанд Монгол Улсын байр суурийг бататгаж буй явдал мөн. Ийнхүү бэхэжсэн байр суурь нь Монгол Улс, гуравдагч талын хоорондын эрх тэгш хамтын ажиллагаа болон Монгол дахь гуравдагч этгээдтэй Монголын төлөө хамтран ажиллах гол нөхцөл болох юм. Үүнийг зарим зөвлөгч нар ч нарийн бодоход илүүдэхгүй биз ээ” гэж 2000 онд тэмдэглэж байсаныг өнөө ч эргэн санах шаардлагатай.

### ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Регионоведение. В.А.Дергачёв, Л.Б.Вардомский. М. 2004. с.4.
2. Хөгжлийн туйл /төв/-ын онол. Онолын энэ чиглэлийн хүрээнд “төв - зах хязгаар нутаг /Center - periphery/-ийн дүн шинжилгээнд ихээхэн ач холбогдол өгдөг байна. “Монгол Улсад бүс нутгуудын хөгжлийн хөтөлбөр боловсруулах онолын үндэс, арга зүй, аргачлал”. УБ. 2004. Л.Цэдэндамба. 15-р тал.
3. Концепции РАН-МГУ и Минрегионразвития: основные различия. Сергей Артоболовский, Институт географии РАН. М. 2007.
4. Analitika.org – Проекты экономической интеграции Китая и Казахстана.  
[www.analitika.org/article.php?story=20060904033625413-45K6](http://www.analitika.org/article.php?story=20060904033625413-45K6)
5. Analitika.org – Проекты экономической интеграции Китая и Казахстана.  
[www.analitika.org/article.php?story=20060904033625413-45K6](http://www.analitika.org/article.php?story=20060904033625413-45K6)
6. [http://ymyt.com/ru/1/304\\_1.shtml](http://ymyt.com/ru/1/304_1.shtml) Уйгурская проблема в рамках ШОС (Казахстан и Китай, 1990-е - начало 2000-х гг.). Савкович Евгений Владимирович, к.и.н., ассистент кафедры Истории и регионоведения Гуманитарного факультета Томского политехнического университета.
7. [http://ymyt.com/ru/1/304\\_1.shtml](http://ymyt.com/ru/1/304_1.shtml) мөн тэнд.
8. Analitika.org – Проекты экономической интеграции Китая и Казахстана.  
[www.analitika.org/article.php?story=20060904033625413-45K6](http://www.analitika.org/article.php?story=20060904033625413-45K6)
9. ОХУ-ын Ерөнхий сайд М.Касьяновын БНХАУ-д хийсэн айлчлал. <http://www.government.ru/content/presscenter/pressroundup/archive/2002/08/22/imported-article905.htm>
10. Ожидается преодоление дисбаланса в расчетах в национальных валютах в приграничной торговле между Китаем и Россией <http://www.legal-way.ru/news304.php>

11. Монгол-Хятадын хамтын ажиллагааны стратеги. Д.Бямбаа, Л.Цэдэндамба, А.Зоригсайхан. Монгол Улсын хөгжлийн судалгаа. УБ. 2009 /1/. 227-р тал.
12. Lhamsurengiin Nyamtseren, Challenges of New Era: Mongolian development Opportunities, 2007. Page 35.
13. У.Баркманн. Шинэ гараа - Монгол - Хятадын сүүлийн жилүүдийн эдийн засгийн харилцааны түвшин, нөхцлийн талаар. 41-р тал. 1990-2003 он хүртэлх Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны тухай. Орчин цагийн Монголын тухай өгүүлүүд. 290-р тал. УБ. 2008.
14. Мөн тэнд.
15. Analitika.org – Проекты экономической интеграции Китая и Казахстана.  
[www.analitika.org/article.php?story=20060904033625413](http://www.analitika.org/article.php?story=20060904033625413) – 45 Кб
16. В Сынцзяне открылась китайско-казахстанская зона свободной торговли <http://www.infoshos.ru/ru/?idn=5285>